

ГАЗАР ЭЗЭМШИГЧ, АШИГЛАГЧ НАРЫН АНХААРАЛД

Нийслэлийн нутаг дэвсгэр дэх газрын суурь үнэ, газрын үнэлгээний бүсийг 21 жилийн дараа Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор шинэчлэн баталлаа.

Нийслэлийн нутаг дэвсгэр дэх газрын суурь үнэ, газрын үнэлгээний бүс шинэчлэгдсэнтэй холбогдуулан Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн 08 дугаар “Газрын үнэлгээний зэрэглэл /бүс/-ийн газрын төлбөр тооцох, итгэлцүүрийн тоон утга, түүнийг хэрэглэх зааг, хязгаарыг тогтоох тухай” тогтоол батлагдсан. Уг тогтоол Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянагдан Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдэн Төрийн мэдээллийн эмхтгэлд хэвлэгдэж www.legalinfo.mn эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд байршаад байна.

Газрын төлбөрийн үнэлгээний бүс, газрын төлбөрийн хэмжээ шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээг шинэчлэх ажил хийгдэж байна.

Иймд газар эзэмшигч, ашиглагч та 2019 оны 07 дугаар сарын 01-ний дотор Чингэлтэй дүүргийн Газрын албанд ирж газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээгээ шинэчлүүлнэ үү.



Дараах холбоосоор орж Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн 08 дугаар тогтоолтой танилцана уу. <https://www.legalinfo.mn/law/details/14013?lawid=14013>